

БАРИМТ БИЧГИЙН МӨН ЧАНАР

Баримт бичгийг маш олон талаас нь, олон янзаар тодорхойлсныг дээр өгүүлсэн. Баримт бичгийн зэрэглэлээс хамаарч баримт бичгийн талаархи ойлголт бараг бүхий л шинжлэх ухааны салбарт нэг буюу нилээд хэдэн янзаар ойлгогддог. Тухайлбал: Мэдээлэл зүй, ном зүй, археограф архив зүй, музей судлал гэх мэт салбарт. Эндээс баримт бичгийг олон талт мөн чанар нь илрэн харагдаж байна.

Эрдэмтэд баримт бичгийн мөн чанарыг системийн хандлагын тусламжтайгаар тайлбарласан байна. Системийн хандлага гэдэг нь нарийн зохион байгуулагдсан зүйл болох систем / Грекээр систем-гэдэг нь олон жижиг хэсгээс бүрдсэн нэгдмэл цул зүйл /-ийг судлах арга, хэрэгслийг боловсруулах явдлыг өөрийн зорилт болгон тавьсан шинжлэх ухаан, арга зүйн чиглэл юм. Баримт бичиг нь өөр хоорондоо хууль ёсоор шүтэлцэн холбогдсон тодорхой нэг бүхэл бүтэн нэгдмэл зүйл, жижиг хэсгүүдийн, өөрөөр хэлбэл элементүүдийн олонлог болох системийг өөртөө агуулж байдаг. Элемент бол баримт бичгийг хуваах туйлын жижиг нэгж бөгөөд системийг бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл-үүргийг гүйцэтгэдэг. Нэг төрлийн элементүүдийн нэгдлийг дэд систем гэнэ. Хэрэв нэг системийн дотор хэд хэдэн жижиг дэд систем байвал тэр систем бүхэлдээ улам нарийн болдог.

Системийн тухай ойлголт нь элементийн тухай ойлголттой харилцан холбоотой зүйл юм. Хэрэв мэдээллийн болон материалаг бодит дэд системтэй тийм баримт бичгийг систем гэж үзвэл мөн л бүтээж бүрдүүлж байгаа элементүүд /нүүр хуудас, хавтас, гадар, хэлбэр гэх мэт/ нь нэгэн нарийн нэгдмэл зүйлс болно. Баримт бичгийн дэд системд тэргүүн өгүүлэл, зүйл, бүлэг, догол мөрнөөс бүрдсэн сэдэв текстийг ч хэлж болно. Баримт бичгийн нэгж элементэд оршил, өмнөх үг, гарчиг, гадар хавтас, загвар гэх мэт зүйлүүд багтана. Баримт бичиг гэдэг бол түүнийг бүрдүүлж буй нэгж элемент, жижиг дэд системүүдийг нэгтгэсэн том систем юм. Тухайлбал, баримт бичигт зайлшгүй байх ёстой мэдээллийн элемент-бүрдлүүд /байгууллагын ба баримт бичгийн нэр, огноо, тамга, тэмдэг, гарын үсэг.../ нь энэ системийн нэг хэсэг билээ.

Зарим тохиолдолд баримт бичиг өөрөөр зарим системийн дэд систем, цаашилбал жижиг элемент, хэсэг болох ч тал бий. Жишээ нь, архивын сан хөмрөгийг нэг систем гэж үзвэл түүний дэд систем, жижиг элемент нь баримт бичиг болно. /Зураг 1-ийг харна уу/



Зураг 1. Баримт бичиг систем, дэд систем, системийн элемент болох нь

Баримт бичиг буюу системийг судлах нь түүний бүтэц, мөн чанарыг илрүүлэхэд дөхөм болдог. Бүх бодит зүйл бусдаас ялгагдах дотоод мөн чанартайн адил баримт бичиг ч гэсэн өөрийн гэсэн олон дотоод мөн чанартай. Тэдгээрээс арай илүү чухал чанаруудыг авч үзье.


Атрибутив чанар. Баримт бичгийн гол шинж нь салшгүй нэмэгдэхүүний нөлөө бөгөөд түүнгүүгээр баримт бичиг бүрэлдэж чадахгүй.

Мэдээлэл+Бодит байдал=Баримт бичиг

Зураг 2. Баримт бичгийн атрибутив чанар

Баримт бичиг нь бүхэл систем мөний хувьд мэдээлэл, бодит зүйл гэсэн хоёр үндсэн зүйлээс бүрдэнэ. Бүрдүүлж буй зүйлсийн нэг нь орхигдвол баримт бичиг баримт биш <<аман яриа>>, <<зүгээр эд>> болно.

Түүнчлэн баримт бичиг нь агуулга /оюун ухааны мөн чанар, үзэл, санаа бодол/ ба хэлбэр /мэдээллийг дамжуулах болон бэхжүүлэхэд үйлчлэх материаллаг болон бодит зүйлс/ гэсэн хоёр нэгдмэл талыг өөртөө агуулна.



Зураг 3. Баримт бичгийн хоёр тал

Баримт бичигт агуулагдсан мэдээллийг дотоод мөн чанар нь түүний гол шинж чанар болдог. Түүнээс гадна хэлбэр бол гол төлөв эд материалын /мэдээлэл тээгч/ болон материаллаг бүтцийн онцлог талаасаа харагддаг. Хүмүүс баримт бичгийн хэлбэрийн гадаад /хэвлэлийн болон бусад чимэглэл/ дотоод /материалын дотоод зохион байгуулагч/ гэж ялгадаг байна.

Функционал чанар. Баримт бичиг бол олон талын үйл ажиллагаатай. Баримт бичиг нь мэдээлэл, мэдлэгийн нийгмийн янз бүрийн шаардлагад тохирсон ерөнхий ба тусгай үйлдлүүдийг гүйцэтгэдэг бөгөөд гол нь мэдээллийн орон зай, цаг хугацаанд дамжуулдаг. Энэ

утгаараа баримт бичиг нь мэдээллийн эх булаг, нийгмийн баримтад харилцааны арга хэрэгсэл юм.

Бүтэцлэгдсэн байдал. Баримт бичиг бүр сэдэв, мэдээллийг бүрдүүлж буй /удиртгал, оршил, тэргүүн хэсэг үндсэн сэдэв, туслах заалт, оруулга гэх мэт/ жижиг элемент, дэд системүүдийн тодорхой дараалалтай, харилцан хамааралтай бүтцийг өөртөө агуулсан байдаг. Янз бүрийн баримт бичгүүдийн хэлбэрийн бүтэц нь тусгай стандарт, нөхцөл, заавраар тодорхойлогддог. /Жишээ нь, манай оронд удирдлагын баримт бичгийн хэлбэрийн бүтцийг MNS.5140-1:2011, MNS.5140-2:2011, MNS.5140-3:2011 стандартуудаар тогтоосон/

Баримт бичгийн шинж чанар, дотоод мөн чанарыг тодорхойлох нь баримт бичиг хөтлөхийн эхлэл төдийгүй цаашид тэднийг төгс гүйцэтгэх, улам тодорхой болгоход дөхөмтэй. Н.Н. Кушнаренок баримт бичгийн онцгой шинж чанаруудад дараах шинж чанарыг хамааруулжээ.

1. Агуулгын ухаалаг тэмдэглэл. Баримт бичиг бол тэмдгээр илэрхийлэгдсэн, оюун ухааны зөөгч юм. Баримт бичгийн агуулга, санааг илэрхийлж байгаа эмх замбараатай тэмдгүүдийн нэгдэл цогц нь түүний гол шинж юм.
2. Гадаад тогтсон хэлбэр. Энэ нь орон зай, цаг хугацааны нөхцөлд мэдээллийг солилцох олон удаа ашиглах, баримт бичгийг урт удаан хугацаагаар хадгалах боломж юм.
3. Нийгмийн харилцаанд ашиглахад зориулагдсан байдал. Баримт бичиг нь бүр анхнаасаа л мэдээллийг цаг хугацаа, орон зайд дамжуулах, хадгалахад зориулагдсан байдаг. Баримт бичиг бол хүний тусгайлан бүтээгдсэн мэдээллийг харилцаанд хүргэх бүхэл бүтэн цогц билээ.
4. Мэдээллийг дуусгасан байдал. Энэ шинж чанар бол баримт бичгийг ашиглахад хэрэгтэй юм. Хагас дутуу гүйцээгээгүй мэдээлэл бол үнэ цэнэтэй баримт бичиг болж чадахгүй. Мэдээллийн төгсгөлийг гүйцэд хийх нь шинжлэх ухаан судалгааны хувьд онцгой ач холбогдолтойг анхаарах хэрэгтэй юм.